


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-12 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **836** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 836 тохиолдлын 93% /776/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 7% /60/ нь орон нутагт (Баян-Өлгий /24/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 215 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **12** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.03.16 - 03.22)

2025 оны эпидемиологийн 12 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **31** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 31%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 40%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-12 дугаар долоо хоногт** нийт **217** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


114Эмнэлгийн
тусламж авч буцсан**103**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 12 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **28** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үетэй ижил байгаа бол сүүлийн 5 жилийн дунджаас 3 дахин өссөн байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 12 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	7	10	17
2	Эмийн хордлого	11	0	11
Нийт		18	10	28

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд 15-40 насныхан байна. **Санамсаргүйгээр** өртсөн тохиолдлын 60%-ийг 0-5 насны хүүхдүүд эзэлж байгаа бөгөөд шил угаагч, хувцас зайлагч зэрэг ахуйн болон цэвэрлэгээний бүтээгдэхүүн, зэв арилгагч, бензин, батарей зэрэг машин, техникийн зориулалттай бүтээгдэхүүнд хордсон байна.

-o0o-